

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН
ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Б.ЛХАМ-ЭРДЭНЭ-ИЙ
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
Зорилт 1. “Зонхилон тохиолдох халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлгийн бодлого боловсруулах”							
1.	Арга хэмжээ 1.1 Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн амын хувь	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
		Нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	16 (2023 он)	-			
		Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэгийн хувь	-	-			

2.	Арга хэмжээ 1.2 Нярайн цогц эрт илрүүлгийг үндэсний түвшинд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангана.	Нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	16 (2023 он)	Нярайн эрт илрүүлгийг үндэсний түвшинд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	Эрүүл мэндийн сайдын санаачилгаар Монгол Улсад Нярайн өвчлөл эндэгдлийг бууруулах үндэсний багийг бүрдүүлсэн бөгөөд тус багийн үйл ажиллагааны хүрээнд Нярайн цогц эрт илрүүлгийг нутагшуулах ажил эхэлсэн. Энэ хүрээнд МУЗГ-аас хэрэгжүүлэх Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээнд НЯРАЙ-зорилтот бүлэгт чиглэсэн пульсоксиметр, сонсгол, нүдний уг дурандах, улаан рефлекс, түнхний эхо, хатаасан толбоны шинжилгээ, зулайн эхо шинжилгээгээр нярайн эмгэгийг эрт илрүүлэх үйл ажиллагааг нэгтгэн оруулсан. Нярайн эрт илрүүлгийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/04 дүгээр тушаалаар нярайн эрт илрүүлгийг зохион байгуулах журам, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор нярайн эрт илрүүлгийг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Нярайн эрт илрүүлгийн бүртгэл, мэдээллийн цахимжилт, тандалтын үйл ажиллагааг шинэчлэн боловсруулж буй А/611 дүгээр тушаалтай уялдуулан эмнэлгийн програм хангамжийг сайжруулж байна. Нярайн эрт илрүүлэг хийх хүний нөөцийг чадавхжуулах	2025.01-06.10	100%
----	--	---	--------------	--	--	---------------	------

					сургалтыг нийслэлийн төрөлт явагддаг төрийн болон хувийн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2025 оны 3 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд хийсэн. Нярайн цогц эрт илрүүлгийг хийх шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийж төрийн сангаас 128 төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн байгууллагуудыг хангахаар тендер зарласан байна. Олон улсын байгууллага болох НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр зүрхний гажиг илрүүлэх хөдөлгөөнт тэсвэртэй пульсоксиметр, Орбис олон улсын байгууллагын дэмжлэгээр нярайн нүдний улаан рефлекс үзэх төхөөрөмжийн асуудлыг тус тус шийдвэрлэсэн.		
3.	Арга хэмжээ 1.3 Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулна.	Хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн амын хувь	16 (2023 он)	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
4.	Арга хэмжээ 1.4 Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах журмыг шинэчлэн боловсруулах, батлуулна.	Батлагдсан журам	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаала	Журмыг батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/04 дүгээр Журам шинэчлэн батлах тухай тушаал батлуулав.	2025.01-06.10	100%

			ар батлагд сан журам				
5.	Арга хэмжээ 1.5 Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах тухай Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан журам боловсруулж, батлуулна.	Батлагдсан журам	ЭМС, БС-ын хамтарсан 2024 оны А/413, А/151 дүгээр тушаала ар батлагдсан удирдамж	Журам боловсруулах Ажлын хэсэг байгуулсан байна.	Журам боловсруулах Ажлын хэсгийг байгуулах тухай тушаалыг боловсруулсан. Газар хэлтсийн дарга нараар тойруулж байна.	2025.01-06.10	70%
6.	Арга хэмжээ 1.6 Ажлын байранд суурилсан эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах тухай Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан журам боловсруулж батлуулна.	Батлагдсан журам	-	Журам боловсруулах Ажлын хэсэг байгуулсан байна.	Журам боловсруулах Ажлын хэсгийг байгуулах тухай тушаалыг боловсруулсан. Газар хэлтсийн дарга нараар тойруулж байна.	2025.01-06.10	70%
7.	Арга хэмжээ 1.7 Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээ (2025-2028), хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Батлагдсан төлөвлөгөө	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
8.	Арга хэмжээ 1.8 Ургийн эрт илрүүлгийн зааврыг боловсруулж батлуулсан байна.	Батлагдсан заавар	-	Заарыг боловсруулсан байна.	Ургийн эрт илрүүлгийн заавар боловсруулах талаар хэд хэд уулзсаны үндсэн албан бичгийг ЭХЭМҮТ-д хүргүүлсэн бөгөөд ЭХЭМҮТ-ээс баг гарч Ургийн эрт илрүүлгийн зааврыг боловсруулсан. Боловсруулсан зааврыг хянаж, засварлан ЭМЯ-ны газрын дарга нараар хянуулж байна.	2025.01-06.10	100%

9.	Арга хэмжээ 1.9 Нярайн эрт илрүүлгийн зааврыг боловсруулж батлуулсан байна.	Батлагдсан заавар	-	Заарыг боловсруулсан байна.	Нярайн эрт илрүүлгийн зааврыг Эрүүл мэндийн сайдын 2024.09.03-ны өдрийн А/375 дугаар тушаалаар батлагдсан Нярайн цогц эрт илрүүлгийг нутагшуулах баг боловсруулсан бөгөөд зааврыг хянаж, засварласан. Газрын дарга нараар хянуулахад бэлэн болгосон.	2025.01-06.10	100%
10.	Арга хэмжээ 1.10 Сургуульд суурилсан эрт илрүүлгийн зааврыг боловсруулж батлуулсан байна.	Батлагдсан заавар	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
11.	Арга хэмжээ 1.11 Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд илрүүлэг үзлэг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг холбогдох нэгжтэй хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна.	Ургийн эрт илрүүлэг: ЭХЭМҮТ-ийн Пренаталогийн төвтэй хамтран 21 аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, хувийн эмнэлгүүдэд "Жирэмсний эхний гурван сарын нийлмэл" илрүүлэг шинжилгээ"-г хийх талаар цахим сургалт 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хийсэн. Нярайн эрт илрүүлэг: Нярайн эрт илрүүлэг хийх хүний нөөцийг чадавхжуулах сургагч багшийг бэлтгэх сургалтыг 2025 оны 3 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Нийслэлийн Өргөө амаржих газар хийсэн. Нийслэлийн төрөлт явагддаг төрийн болон хувийн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 3 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд ЭНЭҮТ-д хийсэн.	2025.01-06.10	100%

					Сургуульд суурилсан эрт илрүүлэг: 6 настны эрт илрүүлгийн хүрээнд нийслэл, орон нутгийн Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 1100 гаруй эмч, сувилагч, мэргэжилтэн, улсын болон хувийн шүдний 580 гаруй эмнэлгийн эмч, техникч, харааны илрүүлэг хийх 1000 орчим ЕБС-ийн эмч, нийгмийн ажилтан, оношилгоо эмчилгээ хийх 21 аймгийн эмч нарыг чадавхжуулсан.		
12.	Арга хэмжээ 1.12 Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд илрүүлэг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг холбогдох нэгжтэй хамтран хийх	Тоног төхөөрөмжийн тоо	-		Ургийн эрт илрүүлэг: Ургийн хромосомын гажгийг илрүүлэх NGS аппаратын техникийн тодорхойлолтыг ЭХЭМҮТ-ийн Пренаталогийн төвтэй хамтран боловсруулж, яамны ХОХ-т хүргүүлсэн. Сонгон шалгаруулалт хийгдэж, гэрээ байгуулах явцтай байна. Нярайн эрт илрүүлэг: 1. Зүрхний гажиг илрүүлэх хөдөлгөөнт тэсвэртэй пульсоксиметр 300-г НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 2. Нярайн нүдний угийн улаан рефлекс шалгах arklight төхөөрөмж 120-г Орбис ОУБ-ын санхүүжилтээр 3. Дутуу нярайн нүдний уг дуран шаардлагатай аймаг, дүүрэгт 128 сая төгрөгийн санхүүжилтээр улсын төсвөөр	2025.01-06.10	100%
				Эрт илрүүлэг хийх тоног төхөөрөмжөөр хангасан байна.			

				4. Сонсголын аппаратыг хөнгөлөлттэй нөхцөлөөр ЭМБ-уудыг өөрсдөөр нь худалдан авахуулах талаар уулзалт хийж, албан бичгүүдийг хүргүүлсэн. Сургуульд суурилсан эрт илрүүлэг: 1. 21 аймаг, 9 дүүргийн 547 АШЭМБ-ыг хүүхдийн ухаалаг ЗЦБ-ийн аппаратаар хангасан. 2. ЗЦБ-ийг унших эксперт эмч нарыг 20 iPad-аар хангасан. 3. Хараа зүйн оношилгоо хийх 14 аймаг, 9 дүүргийн НЭ-т шаардлагатай оптометрийн тоног төхөөрөмжийг 960 сая төгрөгийн санхүүлжилтээр улсын төсвөөр.	Ор-масаа Төлөөлөгч Маарнаа ЗМБ Зүмасаа Ба	
13.	Арга хэмжээ 1.13 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн 6 настнуудад зүрх, нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах	Илрүүлгийн хувь	-	Улсын хэмжээнд 6 настны эрт илрүүлгийн хамрагдалт 94.33 хувь. Нийслэлийн ЕБС-ийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 40,753 хүүхдийн 89.69% нь хамрагдсан байна. Үүнээс зүрхний цахилгаан бичлэгийн өөрчлөлт 21.35%, шүдний цоорол, гажиг 90%, харааны өөрчлөлт 20.4% -д тус тус илэрсэн бөгөөд дараагийн шатны оношилгоо, эмчилгээний явц 17-72%-тай явж байна. https://eruulhuuhed.mn/mainDashboard Орон нутгийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 38,723 хүүхдийн 98.96% нь хамрагдсан байна. Үүнээс зүрхний цахилгаан бичлэгийн илрүүлэгт	2025.01-06.10	100%
			60			

					93.4% орж зүрхний бичлэгийн өөрчлөлт 18.91% гарч 42.11% нь эхо шинжилгээнд, шүдний илрүүлэгт 93.3% орж, шүдний цоорол, гажиг 68.14% илэрч, 91.75% нь эмчлүүлээд байна. Харааны илрүүлэгт 85.6% хамрагдаж, харааны өөрчлөлт 15.1% -д тус тус илэрсэн. https://aimag.eruulhuuhed.mn/mainDashboard		
14.	Арга хэмжээ 1.14 Хөдөө орон нутгийн ЕБС-ийн 6 настуудад зүрх, нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэг хийх эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Зүрх, нүд, шүд 3 чиглэлээр үзлэг хийх нийслэлийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад хараа шалгах, зүрхний эмгэгийг илрүүлэх, шүдний эрт илрүүлэг хийх эмч, сувилагч, шүдний эмч, шүдний эмчийн туслах, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын удирдамж, хөтөлбөрийг батлуулж сургалтыг зохион байгуулав. 6 настны эрт илрүүлгийн хүрээнд нийслэл, орон нутгийн Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 1100 гаруй эмч, сувилагч, мэргэжилтэн, улсын болон хувийн шүдний 580 гаруй эмнэлгийн эмч, техникч, харааны илрүүлэг хийх 1000 орчим ЕБС-ийн эмч, нийгмийн ажилтан, оношилгоо эмчилгээ хийх 21 аймгийн эмч нарыг чадавхжуулсан. 6 настны эрт илрүүлгийн хүний нөөцийг чадавхжуулах цогц сургалтыг Эрүүл мэндийн яам,	2025.01-06.10	100%

					Боловсролын яам, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын ерөнхий газар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургууль, Орбис олон улсын байгууллагаас зохион байгуулсан.		
15.	Арга хэмжээ 1.15 Хөдөө орон нутгийн ЕБС-ийн 6 настнуудад зүрх, нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг холбогдох нэгжтэй хамтран хийх	Тоног төхөөрөмж ийн тоо	-	Эрт илрүүлэг хийх тоног төхөөрөмжөө р хангасан байна.	6 настны эрт илрүүлгийг хийх шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийж төрийн сангаас нийт 2 тэрбум 874 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр анхан шатны эрүүл мэндийн байгууллага, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийг хангахаар тендер зарлаж, зарим тоног төхөөрөмжүүдийг хуваарилаад байна. 1. 21 аймаг, 9 дүүргийн 547 АШЭМБ-ыг хүүхдийн ухаалаг ЗЦБ-ийн аппаратаар хангасан. 2. ЗЦБ-ийг унших эксперт эмч нарыг 20 iPad-аар хангасан. 3. Хараа зүйн оношилгоо хийх 14 аймаг, 9 дүүргийн НЭ-т шаардлагатай оптометрийн тоног төхөөрөмжийг 960 сая төгрөгийн санхүүлжилтээр улсын төсвөөр.	2025.01- 06.10	100%
Зорилт 2. “Зонхилон тохиолдох халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлгийн бодлогыг хэрэгжүүлэх”							
16.	Арга хэмжээ 2.1 Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах “Эрүүл Монгол хүн” арга хэмжээ,	Батлагдсан төлөвлөгөө	-	Арга хэмжээ, төлөвлөгөөг	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах “Эрүүл Монгол хүн” арга хэмжээ, түүнийг	2025.01- 06.10	100%

	түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах			боловсруулсан байна.	хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/64 дүгээр тушаалыг батлуулсан. Арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг биечлэн болон цахим хэлбэрээр 6 удаа зохион байгуулж, төлөвлөгөөгөө хэлэлцүүлсэн. Арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулсан.		
17.	Арга хэмжээ 2.2 Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах “Эрүүл Монгол хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх	Энэ оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	30	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
18.	Арга хэмжээ 2.3 АШЭМБ-ын түвшинд зүрх судасны өвчний менежментийн арга зүйн багцыг хэрэгжүүлэх зааврыг боловсруулах, батлуулах	Батлагдсан заавар	-	Зааврыг боловсруулсан байна.	АШЭМБ-ын түвшинд зүрх судасны өвчний менежментийн арга зүйн багцыг хэрэгжүүлэх зааврыг Эрүүл мэндийн сайдын А/414 дүгээр тушаалаар баталсан Техникийн ажлын хэсгээр 2 удаа хэлэлцүүлж, саналыг тусган төслийг эцэслэн боловсруулж ирэх талаар албан бичгийг Улсын гуравдугаар төв эмнэлэгт хүргүүлсэн. УГТЭ-ийн захирлын тушаалаар Заавар боловсруулах ажлын хэсэг батлагдан Зааврыг	2025.01-06.10	100%

Видео

					боловсруулсан ирүүлсэн. УГТЭ-ийн сайжруулан боловсруулж ирүүлсэн зааврыг хянаж, засварлан ЭМЯ-ны газрын дарга нараар хянуулж байна.		
19.	Арга хэмжээ 2.4 ДЭМБ-ын МонПЭН санаачилгын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлж хэрэгжүүлэх	МонПЭН нэвтэрсэн аймаг дүүргийн тоо	14 аймаг, 3 дүүрэгт нэвтэрсэн, хэрэгжиж байгаа.	6 дүүрэгт нэвтэрч, хэрэгжсэн байна.	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Налайх, Багахангай дүүргийн 112 өрхийн эрүүл мэндийн төвд төвд ДЭМБ-ын ХБӨ/ЗСӨ-ий урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц (PEN/HEARTS)-ыг нэвтрүүлсэн. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн 2025 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдсан. Сургалтад нийт 60 гаруй оролцогчид хамрагдсан. 2025 оны 1 дүгээр сарын 28-31-ний өдрүүдэд Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Налайх, Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмч, удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, АШ ЭМБ- эмч, мэргэжилтнүүд нийт 325 оролцогчдод МОНПЭН хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд НЗДТГ, дүүргүүдийн ЗДТГ-ын удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай ХБӨ-ийг бууруулах чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.	2025.01-06.10	100%

Зорилт 3. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах”							
20.	Арга хэмжээ 3.1 НЭМ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн ажиллах журам боловсруулж, батлуулах	Батлагдсан журам	НЭМ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдсан.	Журмыг боловсруулах	НЭМ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн ажиллах журам боловсруулсан.	2025.01-06.10	100%
21.	Арга хэмжээ 3.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын журмын төслийн боловсруулж, батлуулах	Батлагдсан журам	-	Журмыг боловсруулах	“Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам” батлах Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалыг боловсруулсан. Журмыг газрын дарга нараар хянуулж байна.	2025.01-06.10	100%
22.	Арга хэмжээ 3.3 ЗГҮАХ 2.3.1.4.400 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дэд төв, нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц дүрмийг батлуулна.	Эрүүл мэндийн сайдын тушаал		Холбогдох судалгаа хийх, бүтэц, дүрмийн төслийг боловсруулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар НЭМТ бүтэц, дүрэм боловсруулах Ажлын хэсэг шинээр байгуулагдсан. Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө Төрийн нарийн бичгийн даргаар батлагдсан бөгөөд уулзалт, хэлэлцүүлэг, холбогдох судалгааг хийж, аймаг, дүүргийн НЭМТ, сум, ӨЭМТ, ЭМБ-ны НЭМ-ийн алба,	2025.01-06.10	100%

					нэгжийн бүтцийн төслийг боловсруулсан.		
Зорилт 4. “Халдварт бус өвчний тандалт, судалгааны нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт”							
23.	Арга хэмжээ 4.1 ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн шаталсан 5 дугаар судалгааны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
Зорилт 5. “Сургуулийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх”							
24.	Арга хэмжээ 5.1 ЗГҮАХ 2.2.1.14.332 Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлэг зохион байгуулж, эрүүл мэндийн цахим мэдээллийн сантай болно.	Эрт илрүүлэгт хамрагдсан 6 настны хамрагдалтын хувь	75.2 (2023)	60	Улсын хэмжээнд 6 настны эрт илрүүлгийн хамрагдалт 94.33 хувьтай байна.	2025.01-06.10	100%
25.	Арга хэмжээ 5.2 Сургуулийн орчин дахь суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	Засгийн газрын шийдвэр	-	Хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан байна.	Сургуулийн орчин дахь суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг боловсруулав.	2025.01-06.10	100%
26.	Арга хэмжээ 5.3 ЗГҮАХ 2.3.1.1 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 3.1.1 Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаал	-	Арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулсан байна.	Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025-2028 оны төлөвлөгөөг ЭМС, БС-ын хамтарсан 2025.02.06-ны өдрийн А/53, А/37 дугаар тушаалаар батлуулав.	2025.01-06.10	100%
27.	Арга хэмжээ 5.4 ЗГҮАХ 2.3.1.2.393 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 3.1.1	Хэрэгжилтийн хувь	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-

	Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээг хэрэгжүүлэх						
28.	Арга хэмжээ 5.5 ЕБС-ийн эмч, эрүүл мэндийн багш, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч өнөөгийн байдал нөхцөл байдлын үнэлгээ хий	Үнэлгээний тайлан	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
29.	Арга хэмжээ 5.6 Сургуулийн эмчийн албан тушаалын тодорхойлолтыг батлуулах	Шинэчлэн батлагдсан албан тушаалын тодорхойл олт	-	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-
Зорилт 6. “Уламжлалт анагаах ухааны нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт”							
30.	Арга хэмжээ 6.1 Ард иргэдэд уламжлалт анагаах ухаан аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан мэдээлэл, сурталчилг ааны тоо	-	МС-ны үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	Ард иргэдэд уламжлалт анагаах ухаан аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөр дамжуулан зохион байгуулсан. Тайланг хавсаргав.	2025.01-06.10	100%
Зорилт 7. “Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт”							
31.	Арга хэмжээ 7.1 ЗГҮАХ 2.3.1.3.399 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 3.1.1 Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилти йн хувь	30 (2023)	-	Тайлагнах хугацаа болоогүй.	2025.01-06.10	-

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Нярайн өвчлөл эндэгдлийг бууруулах үндэсний багийн үйл ажиллагааг зохицуулах		-	Үндэсний багийн үйл ажиллагааг зохицуулах	Ажлын хэсэг, үндэсний багийн бүрэлдэхүүнийг ЭМС- ын 2024.09.03-ны өдрийн А/375 дугаар тушаалаар батлуулсан. Тус тушаалын дагуу нярайн тархи хөргөөх эмчилгээг нэвтрүүлж, нутагшуулах, нярайн уушгины артерийн даралт ихсэлтийн оношилгоо, эмчилгээг нутагшуулах, нярайн зүрхний нээлттэй мэс заслыг нутагшуулах, нярайн цогц эрт илрүүлгийг нэвтрүүлж, зохион байгуулах, дутуу төрөлтөөс сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн 5 чиглэлээр төлөвлөгөөг боловсруулав. Тархи хөргөх эмчилгээ хүнд бүтэлттэй төрсөн нярайн тархи хамгаалах зорилгоор улсын хэмжээнд 1 дүгээр шатны тархи хөргөөх эмчилгээг 38 нярайд, 2 дугаар шатны тархи хөргөх эмчилгээг 16 нярайд нийт 54 нярайд хүнд бүтэлтийн улмаас эндэх, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлсэн. Хүнд, хүндэвтэр, архаг бүтэлттэй, цусны сахар багассан 142 нярайд тархины цахилгаан бичлэг хийсэн.	2025.01- 06.10	100%

					Зүрхний хэт авиан шинжилгээгээр уушгины гипертензи оношлогдсон 164 нярайд нитрик оксид эмчилгээг хийсэн. Нярайн эрт илрүүлгийг ЗГҮАХ-т туссан Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээнд тусган хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Нярайн дутуу төрөлтийг бууруулах ажлын хүрээнд 2025 оны 6 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд “Дутуу төрөлт: сэргийлэлт ба дутуу нярайн менежментийн шилдэг туршлага” сэдэвт олон улсын сургалт, семинарыг зохион байгуулав.		
2.	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр		-	Хуулийн төсөл боловсруу	Электрон тамхины зах зээл, маркетингийн судалгааны үр дүн, Тамхины хяналтын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг таницуулах дээд түвшний уулзалт, Электрон тамхины зах зээл, маркетингийн судалгааны үр дүнг танилцуулах салбар дундын уулзалт хэлэлцүүлгийг УИХ-ын Тамгын газар, ДЭМБ-тай хамтран тус тус зохион байгуулсан. Тамхины хяналтын тухай хуулийн төсөлтэй холбоотой УИХ-ын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 11 зүйл, заалттын судалгаа, нотолгоог боловсруулж	2025.01-06.10	100%

					хүргүүлсэн, УИХТГ-аас хуулийн зардлын тооцоолол хийж буйтай холбоотой тамхинаас гаргах эм, эмчилгээний талаар мэдээллийг хүргүүлсэн.. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжүүлэх асуудлаар харьяа байгууллагуудад албан бичиг хүргүүлж, саналуудыг хамтран ажиллаж байна. Дэлхийн тамхигүй өдрийг тэмдэглэн өнгөрөөх өдөрлөгийг Тамхины үнэнийг илчилье сэдвийн хүрээнд залуучуудад чиглэсэн арга хэмжээг Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэнд ДЭМБ, ЕТГ, СЭМҮТ, НЭМҮТ, УГТЭ, ХСҮТ, Азийн анагаахын оюутны холбоотой хамтран зохион байгуулав. Тайлан хавсаргав.		
3.	Сургуулийн өмнөх боловсрол болон Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн нийтлэг агуулга боловсруулах	Агуулга		Агуулга боловсруулах	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын А/54 дүгээр тушаалаар дагуу сургалтын хөтөлбөр боловсруулж ажилласан 1-2 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийг тусгуулсан.	2025.01-06.10	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1		2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.2.1. Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх		Богино хугацааны сургалтад сурсан байна.	- ДЭМБ-ын МонПЭН санаачилгын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын сургалтад 2025.01.28-2025.01.31-ний өдрүүдэд хамрагдсан. - Нярайн эрт илрүүлгийн сургагч багшийн сургалтад 2025 оны 3 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд суралцсан. - 2025 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Харвардын Анагаахын сургуулийн Дэлхийн эрүүл мэнд болон нийгмийн анагаах ухааны тэнхмийн багш Ки Парктай нийгмийн эрүүл мэнд, бодлого асуудлаар уулзалт хийж, туршлагаас суралцав.	2025.01-06.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Халдварт бус өвчний хяналт,
сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан
ахлах шинжээч
(Албан тушаал)

Б.Лхам-Эрдэнэ / 

(Нэр, гарын үсэг)

2025.06.15

(Огноо)